

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд Захиргааны ерөнхий хуулийг баталж, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл, буруу практик гарч байгаа тул уг шалтгааныг эрт илрүүлэх, цаашид хуулийг боловсронгуй болгох зорилгоор Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасны дагуу “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ”-г ХБНГУ-ын Ханнс Зайделийн сантай хамтран захиргааны эрх зүйн эрдэмтэн, судлаач, холбогдох албан хаагчдаас бүрдсэн судалгааны багаар, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хөндлөнгийн судлаачдаар хийлгэсэн бөгөөд хуулийн төслийг дээрх үнэлгээ, судалгаан дээр үндэслэн боловсруулсан болно.

Хуулийн төсөлд дараахь зохицуулалт тусгалаа.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай харилцааг зохицуулж байгаа нь хууль хоорондын давхардал, хийдлийг үүсгэж байгаа бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн уг харилцааг зохицуулж буй Есдүгээр бүлгийн зохицуулалт бодит байдал дээр хэрэглэгдэхгүй байх нөхцөлийг бий болгосон байна.

Иймд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хүчингүй болгож уг хуулиар зохицуулж байгаа харилцааг Захиргааны ерөнхий хуульд нэмж тусгах, ийнхүү тусгахдаа зарим зохицуулалтыг цаг үеийн шаардлага, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн өөрчлөн сайжруулахаар боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа одоогийн хууль тогтоомжоор “өргөдөл”, “гомдол” гэх ойлголтыг хольж зохицуулсан байгааг өөрчилж, гомдол нь иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар захиргааны байгууллагад хандаж байгаа хэлбэр бол өргөдөл нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар саналын шинжтэй, эсхүл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан өөрийн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хүсэлтийн шинжтэй байна гэж ялгаатай байдлаар төсөлд тусгалаа.

Түүнчлэн гомдол нь өөрт хамааралтай буюу эрхийн зөрчил үүссэн гэж үзсэн тохиолдолд захиргааны байгууллагад хандаж байгаа бол өргөдөл нь өөрт хамааралтай боловч хүсэлтийн шинжтэй, эсхүл бүр хамааралгүй саналын шинжтэй

асуудлаар хандаж болохоор ялгаатай байгаагаас хамааран тэдгээрийг шийдвэрлэх журам нь мөн өөр өөр байхаар Захиргааны ерөнхий хуульд тус тусдаа боловч харилцан хамааралгүй бүхий бүлгээр зохицуулахаар төслийг боловсрууллаа.

Мөн одоогийн хууль тогтоомжоор зөвхөн иргэний өргөдөл, гомдол гаргах эрхийг баталгаажуулсан байгааг өргөжүүлж, хуулийн этгээдийн өргөдөл, гомдол гаргах эрхийг мөн хангаж өгөв. Техник, технологийн хөгжлийг даган төрийн байгууллагад иргэн, хуулийн этгээд өргөдөл, гомдлоо цахимаар болон бусад хэлбэрээр гаргах боломжийг хангаж, төрийн байгууллагын өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааг богиносгов.

Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийг сайжруулах буюу практикт хууль хэрэглээнд үүсэж буй хүндрэлийг арилгах зорилгоор сонсох ажиллагааны мэдэгдлийг шууд хүргүүлэх боломжгүй тохиолдлыг шийдвэрлэх, захиргааны акттай холбоотой зохицуулалтын хоёрдмол утга бүхий томъёоллыг нэг мөр ойлгох боломжтой болгож өөрчлөх, захиргааны хэм хэмжээний актын талаарх тайлбар нэмэх, хэм хэмжээний акт батлах талаарх материаллаг зохицуулалтыг нэмж оруулав.

Ерөнхийлөгчийн баталсан захиргааны хэм хэмжээний актыг Улсын Их Хуралд хүргүүлж байх тухай болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан захиргааны хэм хэмжээний актыг бусад субъектын баталсан захиргааны хэм хэмжээний актаас ялгаатай хугацаанд хянаж, бүртгэх эрх бүхий байгууллагад хүргүүлэх тухай өөрчлөлт тусгалаа. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд заасан Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрт хориг тавих эрхийг хязгаарласан, мөн хугацаатай уялдаагүй байгаа хуулийн зохицуулалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх зохицуулалт болох юм.

Мөн Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ болон уг хуулийг үйл ажиллагаандаа хэрэглэдэг байгууллага, судлаачидтай хийсэн хэлэлцүүлгээс нэг мөр хэрэглэхэд хүндрэлтэй, ойлгомжгүй, хоёрдмол утга бүхий бусад зохицуулалтыг тодорхой болгох холбогдох өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, төрийн захиргааны төв байгууллагууд, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага, бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын саналыг албан ёсоор авч төсөлд тусгасан болно.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны www.mojha.gov.mn албан ёсны цахим хуудаст байршуулан иргэд, олон нийт судалж, танилцан, санал өгөх бололцоогоор ханган ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР